# ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨВ АЙМАГТ ТӨЛӨӨЛӨН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

| № | Гэрээний дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | 2025 оны төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | | | | |
| 1 | 3.1.1 | Гэр бүлийн тухай хуулийг хэрэгжүүлж, орон нутагт угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгө өгөх, дэмжих туслах багш ажиллуулан орон нутгийн иргэдийн угийн бичиг хөтлөлтийг зохион байгуулна. | - | Угийн бичгийн хөтлөлтийн хувь | 2018 оны судалгаагаагаар гарсан улсын дундаж үзүүлэлт | Угийн бичгийн хөтлөлтийн асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багш ажиллуулсан байна.Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байна. | Уг удам, өв соёлын холбоо” НҮТББ-ын тэргүүн Ч.Жадамбаатай хамтран 18 аймаг, 9 дүүргийн “Уг удам, өв соёлын холбоо” НҮТББ-ын удирдлага, гишүүдийн туршлага солилцох сургалтыг Төв аймагт зохион байгуулсан. Сургалтад оролцогчид гэр бүлийн андгай өргөх, гэрлэлтийн гэрчилгээг гардуулах, гал таслах ёслолыг зохион байгуулан, төрийн бус байгууллагын тэргүүнүүд сүүлийн 5 жилд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар харилцан ярилцаж, туршлага солилцон, үзэсгэлэн гаргасан. Төв аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлтийн асуудлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжин туслах багшаар “Уг удам, өв соёлын холбоо” НҮТББ-ын тэргүүн Ч.Жадамбааг ажиллуулан, 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 530 иргэнд сургалт зохион байгуулсан. Шинээр 866 өрх шинээр угийн бичгээ хөтөлж, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 53% болж, өмнөх оноос 3%-иар өссөн байна.<br>**Үр дүн:**<br>Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 53% болж, өмнөх оноос 3%-иар өслөө. | 100 |
| 3.1.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар | | | | | | | | |
| 2 | 3.1.2.1 | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга | Гэр бүлийн хөгжил хамгаалал | 1.Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр | 2024 онд гарсан гэр бүлийн | Орон нутгийн гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, | 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2025 оны А/112 дугаар захирамжаар гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх | 0,7 сая төгрөг | боловсруулсан төлөвлөгөө-1 2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн бууралтын хувь | хүчирхийлэлтэй холбоотой хэрэг, зөрчлийн тоо | нөхцөлийг тогтоож, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол, хэрэг, зөрчлийн тоо буурсан байна | хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Монгол гэр бүл” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан, хөтөлбөрийн төслийг 2024-2028 онд хэрэгжүүлэхээр боловсруулсан. Хөтөлбөрийн төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж, 2025 оны А/583 дугаар захирамжаар 4 зорилт, 19 арга хэмжээтэйгээр баталлаа.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 47 бүртгэгдэж, өмнөх оноос 6 хувиар буурч, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 178 бүртгэгдэж, өмнөх оноос 21,9 хувиар өссөн байна.<br>Энэ хүрээнд 2025 онд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх 3 төрлийн сэдвээр сургалт зохион байгуулж, 5815 эцэг эх, асран хамгаалагчийг хамрууллаа.<br>**Үр дүн:**<br>-Гэр бүлийн хүчирхийллийг арилгах чиглэлээр боловсруулсан төлөвлөгөө-1<br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн бууралт-6%<br>Зөрчил 21,9%-иар өссөн | 75 |
| 3 | 3.1.2.2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | 1 Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>2.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувь | 2024 онд зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажлын тоо | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурсан байна. | Олон улсын Гэр бүлийн өдрийг угтаж, гэр бүлийн орчин дахь хүүхдийн эсрэг бэлгийн болон үл хайхрах хүчирхийллийг бууруулах, эцэг эхийн үүрэг, хариуцлага, анхаарал халамжийг сайжруулах, амьдрах ухааны болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, эерэг хандлагатай, үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлдэг гэр бүлийг төлөвшүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл “ГЭР БҮЛДЭЭ-ГЭРЭЛ НЭМЬЕ” 1 сарын | 75 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аяныг аймгийн хэмжээнд зарласан. Аяны хүрээнд сэтгэл зүйч Г.Наранбаатарын "Жаргалтай амьдрах зориг" лекц, 19 суманд "Гэр бүлийн үнэ цэнэ, хайр" сэдвээр тус тус сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, нийт 5815 эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийг хамруулсан. Нийгмийн анхдагч орчин, нэгж болох гэр бүлийн гишүүдийн харилцаа, үүрэг хариуцлага, үнэлэмж, үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөгжих, бие биеэ харилцан хүндэтгэх, эерэг уур амьсгалтай гэр бүлийг алдаршуулах зорилгоор Олон улсын Гэр бүлийн өдрөөр шилдэг "Өв соёлоо түгээн дэлгэрүүлэгч" гэр бүл Эрдэнэсант сумын өрхийн үйлдвэрлэгч С.Буддоржийн гэр бүлийг алдаршуулах нэвтрүүлгийг Төв аймгийн цахим телевизтэй хамтран бэлтгэж, олон нийтэд хүргэж ажилласан. Хандалт 1660.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 47 бүртгэгдэж, өмнөх оноос 6 хувиар буурч, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил 178 бүртгэгдэж, өмнөх оноос 21,9 хувиар өссөн байна.<br>**Үр дүн:**<br>-Зохион байгуулсан арга хэмжээний тоо-22,<br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн бууралт-6%<br>Зөрчил 21,9%-иар өссөн | |
| 4 | 3.1.2.3 | Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр өргөжүүлж, гэр бүлд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, | Хамгаалах нөхөн сэргээх зардлаас 4,0 сая төгрөг | Сэтгэл зүйн тусламж.үйлчилгээ авсан гэр бүлийн тоо | - | Гэр бүлд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ, амьдрах ухааны боловсролын | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Монгол Улсын Засгийн газрын 237 дугаар тогтоолын дагуу сум бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан 2025.02 сараас ажиллаж эхэлсэн. Аймгийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | амьдрах ухааны боловсрол олгох | | | | хүртээмж, чанар сайжирна. | үйлчилгээ үзүүлэн, хүүхэд, гэр бүлд хүрч үйлчлэх 27 сумын 35 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан томилогдон сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг давхардсан тоогоор 1825 хүүхэд, 369 насанд хүрэгч, нийт 2194 иргэнд үзүүлэн ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудыг 3 удаагийн чадавхжуулах сургалтад хамруулан, ганцаарчилсан өрөөгөөр хангагдсан 15, шаардлагатай тоног төхөөрөмжөөр 35 нийгмийн ажилтан хангагдсан байна.<br>Мөн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв"-д сэтгэл зүйчийг орон тоогоор ажиллуулан, 2025 оны жилийн эцсийн байдлаар 43 хүүхэд, 46 насанд хүрэгч, сэтгэл зүйн өдөрлөгт 212 хүүхэд, нийт 301 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлж ажиллалаа.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар "Гэр бүлдээ-Гэрэл нэмье" аян, "Гэр бүлийн боловсрол олгох" сургалт,"Болзоо" нөлөөллийн арга хэмжээ,"Гэр бүлийн андгай өргөх ёслол", "Гэр бүлд зөвлөгөө өгөх төв", "Нэг эцэг эхийн зөвлөл-Нэг бүтээлч ажил", "Аз жаргалтай эмэгтэй клуб" , "Гэр бүлийн өдрийн тухай" захирамжийн хэрэгжилт, "Нийгмийн ажилтныг чадавхжуулах" сэтгэл зүйн ментор хөтөлбөр, "Сэтгэл зүйн өдөрлөг" зэрэг нийт 279 удаагийн нөлөөллийн арга хэмжээнд 18790 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулж, нийт гэр бүлийн 65%-д хүрч ажилласан. /Нийт гэр бүлийн тоо 28896/<br>**Үр дүн:** | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авсан гэр бүлийн тоо - 18790 хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулж, нийт гэр бүлийн 65% хүрсэн. | |
| 5 | 3.1.2.4 | Орон нутгийн жилийн төсвийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хохирогчид үйлчилгээнд шаардагдах зардлыг төсөвт тусгаж, батлуулах | - | 1 Батлагдсан төсөв-100%<br>2.Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт 95%-иас дээш түвшинд биелэх | 2024 онд баталсан төсөв | Орон нутгийн төсөвт урсгал зардал, үйл ажиллагааны зардал, үйлчилгээний зардлыг 100% тусгаж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанар нэмэгдсэн байна. | Аймгийн хохирогчийг түр хамгаалах өрөө нь Замын цагдаагийн байранд байрладаг бөгөөд 2025 онд тус газар их засварт орсон. Иймд 2025 оны жилийн эцсийн байдлаар хохирогч хүлээн аваагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд Улаанбаатар хотын хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байранд 5 сумын 6 өрхийн 10 хүүхдийг холбон зуучиллаа.<br>Аймгийн ГХУСАЗЗөвлөлийн 2025 оны төсөвт түр хамгаалах байрны урсгал засварт 3,0 төгрөгийг шийдвэрлэн зарцуулсан.<br>Мөг сумдын хамтарсан багийн үйл ажиллагаа болон хүүхэд хамгааллын зардалд 16 сум нийт 643.571.700 төгрөгийг батлуулан 428.7 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>**Үр дүн:**<br>- Орон нутгийн төсөвт тусгасан урсгал, үйл ажиллагааны зардал- 646,371,700<br>-Зардлын хуваарилалт, үйл ажиллагааны хэрэгжилт -67,07% | 65 |
| 3.1.3 Хүүхдийн эрхийн талаар | | | | | | | | 95 |
| 6 | 3.1.3.1 | Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх | Хүүхэд хамгааллын зардал-10.7 сая төгрөг | 1 Төлөвлөгөө баталсан эсэх<br>2 Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангахад салбар бүрийн оролцоо сайжирсан байна. | Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны салбар дундын төлөвлөгөөг хүүхдийн үндсэн 4 эрхийн хүрээнд 26 арга хэмжээтэй төлөвлөн хэрэгжүүлж, 428.7 сая төгрөгийг зарцууллаа.<br>Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны 3 дугаар улирлын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн 6 дугаар хэлэлцүүлж, 87,3%-тай дүгнэгдлээ. 2025 оны жилийн эцсийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдлаар хэрэгжилт 95,7% болж өмнөх оноос 1,7%-иар өслөө.<br>2025 онд хүүхдийн эрхийг хангах болон хөгжил, хамгааллын чиглэлээр:<br>- Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, тэдний санал санаачилгыг шийдвэр гаргах түвшний хүмүүст уламжлах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор “Teen education”, “Хүүхдийн дотоод ертөнц” хөтөлбөр, Good vibe өдөрлөг, Career mentor өдөрлөг зэрэг 12 төрлийн арга хэмжээг санаачлан зохион байгуулж, 4700 гаруй хүүхдийг хамруулсан байна.<br>-Насанд хүрээгүй хүнд электрон тамхи, дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох талаарх худалдаа, үйлчилгээний газруудад уриалгыг хүргэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Цагдаагийн газар, Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс хамтран 3 удаагийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгууллаа. Төв аймгийн Цагдаагийн газраас 6 сумын 11 сургуулийн 2900 сурагчид үе тэнгийн дээрэлхэлт, цахим орчны зөв хэрэглээ, электрон тамхины хор уршиг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.<br>-Сургуульд суурилсан 1 дүгээр ангийн сурагчдын урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн нүдний үзлэг 93,7%, зүрх судасны үзлэг 97,8%, шүдний үзлэг 76,8% тай явагдаж байна.<br>Мөн аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 40 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 19 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр аймгийн Хүүхдийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөө зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулсан.2025 оны жилийн эцсийн байдлаар тус хороогоор 58 хүүхдэд үйлчилгээ үзүүлснээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 хүүхдэд зан үйлийг засах сургалтын төлөвлөгөө боловсруулан сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж байна.Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 10 хүүхдэд кейс нээн сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлан, боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, хууль зүйн буюу өмгөөллийн үйлчилгээ зэргийг үзүүлэн ажиллаж байна. Дээрх үйлчилгээнд хүүхэд хамгааллын зардлаас 11,0 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>- Гамшиг онцгой нөхцөл байдалд өртсөн болон хамгааллын үйлчилгээ шаардлагатай Цээл, Жаргалант, Баянхангай, Аргалант, Лүн, Баянцогт, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Сүмбэр, Зуунмод зэрэг 10 сумдын 156 хүүхдэд хүнсний багц, хувцас хичээлийн хэрэглэл, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 27 сумын 773 хүүхдэд дүрэмт болон дулаан хувцас, ахуйн багц, амин дэм олгосон. Мөн ДЗОУБ-аас эрсдэлт нөхцөл дэх 20 өрхийн 64 хүүхдийн ар гэрт 200 сая төгрөгийн гэр, ахуйн болон хүнсний багцын дэмжлэгийг үзүүлсэн.<br>**Үр дүн:**<br>- Төлөвлөгөө баталсан эсэх-Тийм<br>- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95,7% | |
| 7 | | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний | ХХО- 12,5 сая, УСАХэмжээний | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн | 2024 онд хамрагдсан хүүхдийн | Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 25 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх хүүхэд залуучуудын ордны 16 төрлийн дугуйлан, сонгон, секц сургалтад 935 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.1.3.2 | хүртээмжийг сайжруулах, хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх | зардал 7,7 сая | орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь | тоо | хувиар өссөн байна | хүүхэд, Биеийн тамир, спортын газрын дэргэдэх спортын 25 төрлийн секц, дугуйланд 11,561 хүүхэд, Ерөнхий боловсролын 32 сургуулийн дэргэдэх 18 төрлийн дугуйланд 17,792 сурагч, 21 сумын Соёлын төвийн 14 төрлийн дугуйланд 2,421 хүүхэд, 12 сумын Соёл, спортын цогцолборт 5 төрлийн дугуйлан секцэд 1,438 хүүхэд, залуучууд хамрагдсан. Нийт давхардсан тоогоор 34,147 хүүхэд хөгжлийн чиглэлийн дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан нь өмнөх оноос 36,6%-иар өссөн байна.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар хүүхдийн хөгжил оролцоог дэмжих авьяас чадварыг нээн хөгжүүлэх чиглэлээр 11 төрлийн тэмцээн, уралдааныг зохион байгуулж, 7464 хүүхдийг хамруулан ажиллалаа. Мөн Зуунмод сумын Соёлын төвийн дэргэдэх “Хөх эгшиглэн” үндэсний хөгжмийн дугуйлан, бүжгийн дугуйлан, SAS дууны дугуйлан, “Эв нэгдэл” таеквондо клуб, Япон хэлний дугуйлан, “Залуу зохион бүтээх төв” зэрэг нийт 6 дугуйлан секцийн үйл ажиллагаанд 6,033,050 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>2025 онд “Дэлхийн зөн” ОУБ-ын ТОНХ-тэй хамтран 6 сумын хүүхдийн санаачилсан хүүхэд хамгааллын-3, хүүхдэд ээлтэй орчны-1, нөлөөллийн-1, хүүхдийн хөгжлийн-1, байгаль орчны-1, цаг уурын өөрчлөлтийн-1 зэрэг нийт 8 төслийг дэмжиж ажилласан.<br>**Үр дүн:**<br>Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн орон нутгийн нийт хүүхдэд эзлэх хувь- давхардсан тоогоор 34,147 хүүхэд буюу 100%, өмнөх оноос 36,6%-иар өссөн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | 3.1.3.3 | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тухай шатны ИТХ-аар батлуулах | - | Баталсан төсвийн хэмжээ | 2024 онд баталсан төсөв | "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжсэн байна | Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих нийгмийн үйлчилгээний чанар, салбар хоорондын уялдааг хангах салбар зөвлөлийн 2023-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт, 24 арга хэмжээтэйгээр 2023 оны А/705 дугаар захирамжаар батлан хэрэгжүүлж байна.<br>НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвд олон нийтийн оролцоонд түшиглэсэн "Бага насны хүүхдийн цогц хөгжлийн төв"-ийг бий болголоо.<br>Мөн НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга зүй" СӨБ-ийн шинэчлэл сэдэвт сургалтуудыг зохион байгуулж 220 гаруй албан хаагчийг хамрууллаа.<br>**Үр дүн:**<br>Зарцуулсан хөрөнгийн хэмжээ-70,0 сая | 70 |
| 9 | 3.1.3.4 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дүгээр заалтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | - | 1.Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо<br>2.Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төг/ | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангасан байна | 2025 оны 01/831 дугаар албан бичгээр "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангуулах мэдэгдлийг 27 сумын Засаг даргад хүргүүлсэн. 2025 онд тус хуулийн 22.9-д заасан дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сангийн суурин төлөөлөгч Эваристе Коуасси-Комлан болон хөрөнгө оруулагч Хаан банк, Номин холдинг ХХК-ийн удирдлагатай Батсүмбэр сумын Цогт-Өндөр, Үдлэг багт "Багийн бага сургууль" төслийн хэрэгжүүлж, тус 75 хүүхдийн хүчин чадалтай 2,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий бага сургуулийг шинээр барихаар гэрээнд гарын үсэг зурлаа.<br>Төслийн 1,423,432,000 төгрөгийг Хаан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | банк, 325,478,826 төгрөгийг НҮБ-ын Хүүхдийн сан, 500,000,000 төгрөгийг Номин Фүүдс Интернэйшнл ХХК, 388,000,000 төгрөгийг Номин Реалтор ХХК, орон нутгийн төсвөөс 200,000,000 төгрөгийн санхүүжилтээр “БАГИЙН БАГА” сургууль баригдаж байна<br>**Үр дүн:**<br>- Тухайн жилийн татвар ногдох орлогоос 1 хүртэлх хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан байгууллагын тоо -2<br>- Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төг/- 2,2 тэрбум | |
| 10 | 3.1.3.5 | Аймгийн Хүүхдийн зөвлөл, хүүхдийн оролцооны байгууллагуудыг байр танхимаар хангах, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцоог хангах ажиллах | ХХО-ны зардал 1,0 сая төгрөг | Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо | - | Хүүхдийн оролцооны Байгууллагуудын үйл ажиллагаа сайжирсан байна | Аймгийн Хүүхдийн зөвлөл, Өсвөрийн сэтгүүлч клуб, “Eco warriors” эко клуб, “khumuun debate” мэтгэлцээний клуб, “Tuv teenagers” сэтгэл судлалын клуб, “Өсвөрийн эмч” клуб, “Улаан загалмай” клуб зэрэг 7 хүүхдийн оролцооны байгууллагатай хамтран 24 төрлийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, байр танхимаар хanган хамтран ажилласан.<br>Аймгийн 19 сумын Ерөнхий боловсролын сургуулийн эко бүлгэм болон хүүхдийн оролцооны байгууллагын 100 хүүхдийг хамруулан “YOUTH POWER IN TUV” байгальд ээлтэй залуусын чуулганыг Зуунмод хотноо зохион байгуулж, оролцогчид 3 төрлийн илтгэл, 3 дэд сэдвийн дагуу багийн ажлыг өрнүүлж, тунхаг бичиг гаргаж, аймгийн удирдлагуудад өгсөн.<br>Монгол Улсын Их Хурал, НҮБ-ын Хүүхдийн сан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Монголын Скаутын холбоотой хамтран хэрэгжүүлдэг "Өсвөрийн парламент-2025" хөтөлбөрт Зуунмод | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сумын 1 дүгээр сургуулийн 12 дугаар ангийн сурагч Е.Баяртогтох, Б.Бат-Энэрэл, 2 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагч Г.Нандин-Эрдэнэ нар шалгарсан.<br>Мөн аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн, гишүүн 2 сурагч төлөөлөгч гишүүнээр ажиллаж, шийдвэр гаргах түвшинд оролцоог ханган ажиллаж байна.<br>Хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, шийдвэр гаргах түвшинд оролцох эрхийг нь ханган хүүхдийн дуу хоолойг сонсох зорилгоор аймгийн хэмжээнд "Хүүхдээ сонсох өдөр"-ийг зохион байгуулж, уулзалтаар гарсан 255 санал, хүсэлтийг хяналтад авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, үе шаттайгаар шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>**Үр дүн:**<br>-Байр танхимаар хангасан оролцооны байгууллагын тоо- 7 | |
| 11 | 3.1.3.6 | "Олон нийтийн байцаагч "-ийг ажиллуулж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх | | 1. Олон нийтийн байцаагчийн тоо<br>2.Илрүүлсэн хүүхдийн тоо | - | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 50 хувиар өссөн байна. | Сумдын хамтарсан багтай хамтран эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх, хамгааллын арга хэмжээнд хамруулахаар аймгийн хэмжээнд 21 суманд 30 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж байна.<br>Эрсдэлт нөхцөл дэх хүүхдийг илрүүлэх, хамгааллын шуурхай үйлчилгээг хүргэх зорилгоор "Хайрлая, хамтаръя", "Асуудал шийдэл" 2 удаагийн аян зохион байгуулж, 4800 өрхөд гэр бүлийн болон хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэл бүхий 2367 хүүхдийг илрүүлэн, шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, хөгжлийн үйлчилгээнд 1991 хүүхэд буюу 84.1%- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ийг, хамгааллын үйлчилгээнд 1305 хүүхэд буюу 55.1%-ийг хамруулсан.<br>2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн илрүүлэлт өмнөх оноос 790 нэгж буюу 50,1%-иар өссөн.<br>ЭНБХ-дэд хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэйгээс 20, дунд эрсдэлтэйгээс 230, нийт 250 хүүхдийн эрсдэлийн түвшин буурсан нь нийт ЭНБХ-ийн түвшин 15%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>Гамшиг онцгой нөхцөл байдалд өртсөн болон хамгааллын үйлчилгээ шаардлагатай Цээл, Жаргалант, Баянхангай, Аргалант, Лүн, Баянцогт, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Сүмбэр, Зуунмод зэрэг 10 сумдын 156 хүүхдэд хүнсний багц, хувцас хичээлийн хэрэглэл, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 27 сумын 773 хүүхдэд дүрэмт болон дулаан хувцас, ахуйн багц, амин дэм олгосон. Мөн ДЗОУБ-аас эрсдэлт нөхцөл дэх 20 өрхийн 64 хүүхдийн ар гэрт 200 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ<br>**Үр дүн:**<br>- Олон нийтийн байцаагчийн тоо-30,<br>- Илрүүлсэн хүүхдийн тоо-өмнөх оноос 790 нэгж буюу 50,1%-иар өссөн. | |
| 3.1.4. Хүүхэд хамгааллын талаар | | | | | | | | 96.97 |
| 12 | 3.1.4.1 | “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг сурталчлан таниулж, салбар бүрд мөрдүүлэх | Гэр бүлийн хөгжил хамгаалал-1,4 сая төгрөг | Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо | - | Орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төр. хувийн хэвшлийн байгууллагын 80 хувьд хүүхэд хамгааллын бодлогыг | Байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд хамгааллын бодлогыг сурталчлан таниулах, хүүхэд хамгааллын бодлого батлуулан хэрэгжилтийг хангах зорилгоор “Хайрын шүхэр” ТББ-ын тэргүүн Д.Бадамцэцэгээс зөвлөх үйлчилгээ авч, төрийн 26 байгууллагын 360 албан хаагчид сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | 78.85 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөрдүүлсэн байна. | Мөн аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн даргын 2025 оны 06/1724 албан бичгээр байгууллага, аж ахуйн нэгжид Хүүхэд хамгааллын бодлогыг батлуулан мөрдөх чиглэлийг хүргүүлж, шинээр 23 байгууллага хүүхэд хамгааллын бодлогоо батлаад байна. Өмнөх онд боловсролын салбар-76, нийгмийн салбар-10, бусад салбар-26, нийт-112 төрийн байгууллага хүүхэд хамгааллын бодлого батлуулсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 135 байгууллага буюу нийт төрийн байгууллагын 63,08% нь хүүхэд хамгааллын бодлогоо батлан хэрэгжилтийг хханган ажиллаж байна.<br>**Үр дүн:**<br>-Хүүхэд хамгааллын бодлого мөрдсөн байгууллагын тоо - 135 байгууллага буюу нийт төрийн байгууллагын 63,08% | |
| 13 | 3.1.4.2 | Орон нутгийн хэмжээнд 2020-2024 онд хүүхэд хамгааллын үйчилгээ авсан хүүхэд, үрчлэгдсэн хүүхэд, бүтэн өнчин хүүхдийн нөхцөлд байдалд үнэлгээ хийж, мэдээллийн санд бүртгэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг бүрэн хүргэх | Хүүхэд хамгааллын зардал - 24,5 сая төгрөг | Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо | - | Хүүхэд хамгааллын үйлчилгээ шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж. үйлчилгээг бүрэн хүргэсэн байна | Эрсдэлт нөхцөлд 2020 онд-976, 2021 онд-2771, 2022 онд-1150, 2023 онд-1078, 2024 онд-1577, 2025 онд 2367 хүүхэд судалгаанд хамрагдаж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг тухай бүр үзүүлж ажилласан.<br>-Аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2367 хүүхдийг илрүүлэн, шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, хөгжлийн үйлчилгээнд 1991 хүүхэд буюу 84.1%-ийг, хамгааллын үйлчилгээнд 1305 хүүхэд буюу 55.1%-ийг хамруулсан. ЭНБХ-дэд хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэйгээс 20, дунд эрсдэлтэйгээс 230, нийт 250 хүүхдийн эрсдэлийн түвшин буурсан нь нийт ЭНБХ-ийн түвшин 15%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>Гамшиг онцгой нөхцөл байдалд өртсөн болон хамгааллын үйлчилгээ | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлагатай Цээл, Жаргалант, Баянхангай, Аргалант, Лүн, Баянцогт, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Сүмбэр, Зуунмод зэрэг 10 сумдын 156 хүүхдэд хүсний багц, хувцас хичээлийн хэрэглэл, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 27 сумын 773 хүүхдэд дүрэмт болон дулаан хувцас, ахуйн багц, амин дэм олгосон. Мөн ДЗОУБ-аас эрсдэлт нөхцөл дэх 20 өрхийн 64 хүүхдийн ар гэрт 200 сая төгрөгийн гэр, ахуйн болон хүнсний багцын дэмжлэгийг үзүүлсэн.<br>**Үр дүн:**<br>- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн тоо- 2367 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, шаардлагатай хүүхэд бүрд кейс нээж. үйлчилгээг бүрэн хүргэлээ | |
| 14 | 3.1.4.3 | Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, шаардлагатай зардлыг орон нутгийн төсвөөс хуваарилаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч хүүхэд бүрд үйдчилгээг бүрэн хүргэх | Хүүхэд хамгааллын зардал - 10,3сая | 1. Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв;<br>2. Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь | 26,7 хувь | Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйлчилгээ авах шаардлагатай хүүхэд бүрд үйлчилгээг бүрэн хүргэсэн байна. | Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 40 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн батлуулж, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт 19 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулсан.2025 оны жилийн эцсийн байдлаар тус хороогоор 58 хүүхдэд үйлчилгээ үзүүлснээс хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 3 хүүхдэд зан үйлийг засах сургалтын төлөвлөгөө боловсруулан сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж байна.Бэлгийн хүчирхийлэлд өртсөн 10 хүүхдэд кейс нээн сэтгэл зүй, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлан, боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах, хууль зүйн буюу өмгөөллийн үйлчилгээ зэргийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үзүүлэн ажиллаж байна. Дээрх үйлчилгээнд хүүхэд хамгааллын зардлаас 10,3 сая төгрөгийг зарцуулаад байна.<br>**Үр дүн:**<br>- Орон нутгийн төсвөөс хуваарилсан төсөв- 10,3 сая;<br>- Хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхдийн үйлчилгээ авах шаардлагатай нийт хүүхдэд эзлэх хувь-22,4% | |
| 15 | 3.1.4.4 | Хурдан морины уралдаан болон морины сунгаа, уралдааны бэлтгэлийн үед уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хяналт тавих | хамгаалах нөхөн сэргээх зардлаас-3,5 сая төгрөг | 1 Хяналт, шалгалтын тоо,<br>2.Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь | - | Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдал 95 хувь хангагдсан байна | 2025 оны “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” А/67 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 1 зөвлөмж, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын 1 чиглэлийг сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт хүргүүлсэн. Мөн 2025 оны А/169 дугаар захирамжийг хэрэгжүүлэн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын 2025 оны А/63 дугаар тушаалаар Зуунмод, Лүн, Баянцагаан, Аргалант, Цээл сумдад зохион байгуулсан хурдан морины хаврын бүсийн уралдаанд уралдаанч хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан. Хурдан морины уралдааны гарааны үед стандартын шаардлага хангаагүй малгайтай 9, өвдгөвч, тохойвч хэрэглээгүй 6 уралдаанч хүүхдийг илрүүлэн шаардлага тавьж зөрчлийг 100% арилгуулсан.<br>Хурдан морины уралдаан ихээр зохион байгуулагддаг Баян, Баянжаргалан сумдын уяачдын холбооны тэргүүн, уяач нийт 95 иргэнд хурдан морь уралдаанч хүүхдийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт өртөхөөс урьдчилан сэргийлэх, морины бэлтгэл ажлын үед хамгаалалтын хувцас хэрэгсэл | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэглүүлж хэвших талаар сургалт зохион байгуулсан. Мөн Жаргалант, Зуунмод, Сэргэлэн сумдын багийн хуралд оролцсон 685 иргэнд хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлын хангах талаар яриа таниулга хийж, 3 төрлийн гарын авлагыг тарааж ажиллалаа.<br>Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Цагдаагийн газартай хамтран Зуунмод сумын Зүүндэлгэр 4-р баг болон Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт хурдан морины үсэргээнд насанд хүрээгүй хүн оролцуулж байгаа эсэхэд 5 удаагийн хяналт шалгалт хийж, уяачдад зөвлөгөө мэдээлэл өгч, 10 зөрчил илрүүлж холбогдогчийг Зөрчлийн тухай хуулийн 6.20 зүйлийн 3.3-т заасанаар 500,000 нэгжээр торгосон.<br>Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар аймаг, сумын Засаг даргын зөвшөөрөлтэй нийт 55 удаагийн хурдан морины уралдаан зохион байгуулагдаж 1013 уралдаанч хүүхэд оролцож 30 хүүхэд мориноос унаж аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн үзлэгээр 2 хүүхэд хөнгөн, 28 хүүхэд бэртэлгүй гэж оношлогдсон.<br>**Үр дүн:**<br>- Хяналт, шалгалтын тоо- 10,<br>- Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлтийн хувь-100 | |
| 16 | 3.1.4.5 | Гамшиг онцгой байдлын үе, ган, зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын | хамгаалах нөхөн сэргээх зардал-4,4 сая төгрөг | Үйлчилгээ авсан өрхийн тоо, хүүхдийн тоо | MNS 6948:2021, Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд | Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал сайжирсан байна | Гамшиг онцгой нөхцөл байдалд өртсөн болон хамгааллын үйлчилгээ шаардлагатай Цээл, Жаргалант, Баянхангай, Аргалант, Лүн, Баянцогт, Мөнгөнморьт, Баяндэлгэр, Сүмбэр, Зуунмод зэрэг 10 сумдын 156 хүүхдэд хүнсний багц, хувцас хичээлийн хэрэглэл, эрсдэлт нөхцөлд амьдарч | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | | | хамгаалал Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага | | байгаа 27 сумын 773 хүүхдэд дүрэмт болон дулаан хувцас, ахуйн багц, амин дэм олгосон. Мөн ДЗОУБ-аас эрсдэлт нөхцөл дэх 20 өрхийн 64 хүүхдийн ар гэрт 200 сая төгрөгийн гэр, ахуйн болон хүнсний багцын дэмжлэгийг үзүүлсэн.<br>Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Онцгой байдлын газар, Дэлхийн Зөн Төв Орон нутгийн хөтөлбөр хамтран байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал, болзошгүй гамшгийн эрсдэлийг олон нийтийн болон өөрсдийн оролцоотой тодорхойлж, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох зорилготой сургалтыг 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, сургалтад байгууллагын 22 алба хаагч хамрагдсан. Мөн ОБЕГ-ын дэргэдэх Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, НҮБ-ын Хүүхдийн сан, Монголын Хүүхдийн зөвлөл хамтран хэрэгжүүлсэн B.E.S.T хөтөлбөрийн хүрээнд үе тэнгийн сургагч багшийг бэлтгэж, хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сурагч багш (аймгийн Хүүхдийн зөвлөлийн гишүүн сурагч Е.Баяртогтох)-тай хамтран Зуунмод сумын “Бумбардай” цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 35 хүүхдэд сургалт зохион байгуулсан.<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын төлөвлөгөөнд тодотгол хийж, 2025 оны гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын төлөвлөгөөг 4 зорилт 15 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр баталж, 93,3%-ийн хэрэгжүүлсэн. Энэ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүрээнд галын аюулын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, самбарыг байршуулах, барилга байшин объектыг галын аюулаас хамгаалах, гал гарах анхны шинж тэмдгүүдийг илрүүлэн мэдээлэх галын дохиоллын системийг засварлах шаардлагатай дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хэвийн галын хорыг картлуулах, галын аюулгүй байдлын тэмдгүүдийг байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>**Үр дүн:**<br>Үйлчилгээ авсан өрхийн тоо- 516, хүүхдийн тоо-993 | |
| 17 | 3.1.4.6 | Хүүхдийн тоглоомын талбай, орон сууцны гэрэлтүүлэг, цахилгааны сүлжээний аюулгүй байдал, замын далан, ухсан нүх, суваг, шуудуу, траншей, худаг орчимд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, анхааруулах тэмдэг байршуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | ОНТ-0,3 сая төгрөг | Осол гэмтлийн буурсан хувь | - | Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлгэй орчин бүрдүүлсэн байна | Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын 2025 оны А/137 дугаар албан бичгээр сумдын Хүүхдийн төлөө зөвлөлүүд харьяа нутаг дэвсгэрийн тоглоомын талбайд хяналт шалгалтыг зохион байгууллаа.<br>Тоглоомын талбайн хяналт шалгалтыг 24 сумын 134 тоглоомын талбайд 2 удаа хийж, нийт 130 зөрчлийг илрүүлэн 119 зөрчлийг арилгуулж 4373,0 төгрөг зарцуулан зөрчил арилгалт 91,5% шийдвэрлэгдсэн. 2025 онд аймгийн хэмжээнд 3 нийтийн эзэмшлийн тоглоомын талбайг шинээр байгуулж, 2 тоглоомын талбай бүтэн засварлагдаж орон нутгийн хөгжлийн сан болон сумын төсвийн хөрөнгө оруулалтаас 180 сая төгрөг зарцуулсан.<br>**Үр дүн:**<br>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаж, хүүхдэд ээлгүй орчин бүрдүүлсэн байх - 130 зөрчлийг илрүүлэн 119 зөрчлийг арилгуулж 4373,0 төгрөг зарцуулан зөрчил арилгалт 91,5% | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 3.1.4.7 | Хүүхдийн хөгжил сургалтын төв, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйчилгээ, сүм хийд, худалдаа үйчилгээний газар, амралт сувилал, аялал жуулчлалын газруудад хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах | - | Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь | - | Хүүхдийн эрх зөрчсөн байгууллагын үйл ажиллагааг хаах, хязгаарлах арга хэмжээ авч, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулсан байна | Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд Хүүхдийн зуслан, ЕБСургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн тоглоомын талбай зэрэг 38 объектад хяналт шалгалт 22 зөрчил илрүүлж, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 4 зөвлөмж, 1 албан шаардлага, 1 мэдэгдэл хүргүүлж зөрчил арилгалт 81,8% буюу 80% буурсан байна. Мөн хяналт шалгалтаар илэрсэн 1 хүүхдийн эрхийн зөрчлийн гомдол мэдээллээр бүртгэн авч зөрчлийн 2534000455 дугаартай хэрэг нээж холбогдогч 2 этгээдэд тус бүр 100000 төгрөгийн торгууль оногдуулсан байна.<br>**Үр дүн:**<br>Хүүхдийн эрхийн зөрчил буурсан хувь-80% | 100 |
| Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | | | | |
| 3.2.1 Хөдөлмөрийн харилцааны талаар | | | | | | | | 100 |
| 19 | 3.2.1.1 | Зохистой хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг бий болгохтой холбоотой Хөдөлмөрийн хуулийн зохицуулалтыг орон нутгийн хэмжээнд ажил олгогч, ажилтанд сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах; | 1741729,0 | Хамрагдсан салбар. ААНБ-ын тоо | Улсын хэмжээнд 2024 онд 17 салбарын 400 иргэн хамрагдсан | ААНБ, иргэд, олон нийтийн хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг ойголтыг нэмэгдүүлж. хуулийн хэрэгжилт сайжирсан байна | Хөдөлмөрийн яармаг, ажил олгогчдын уулзалт, ХАБЭА-н сарын аян, байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг 32 арга хэмжээнд нийт 10 гаруй салбарын 132 байгууллага, 371 ажилтан, 183 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд Хөдөлмөрийн гэрээний гол нөхцөл, нэмэгдэл хөлс, хамтын гэрээ байгуулах тухай танилцуулж, 3 төрлийн шторк, 10 постерийг олон нийтийн мэдээллийн сүлжээнд байршуулан, 3 удаагийн шууд бичлэгээр 400 гаруй иргэдэд мэдээлэл өгч Хөдөлмөрийн тухай хуулийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүллээ.<br>**Үр дүн:**<br>Хамрагдсан салбарын тоо 10<br>ААНБ-н тоо 132 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | 3.2.1.2 | Орон нутаг дахь бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, ажил олгогчийн дэмжих хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг дэмжих (хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр)-ийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх | | 1.Хамрагдсан ААНБ-ын байгууллагын тоо<br>2 Зохион байгуулсан сургалтын тоо | - | Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт сайжирч, хөдөлмөрийн харилцааны соёлыг төлөвшүүлсэн байна. | Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн харилцааны хөтөлбөрийг 48 аж ахуйн нэгжид сурталчилж, сургалтын арга хэмжээнд барилгын салбарын 17 байгууллагын 35 удирдах албан хаагч, зөвлөх үйлчилгээнд 3 байгууллагыг хамруулж, Хөдөлмөрийн харилцааны чиглэлээр 23, ХАБЭА-н тухай хууль тогтоомжийн чиглэлээр 12, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн чиглэлээр 5, нийт 37 баримт бичгийг шинээр боловсруулах, сайжруулахад дэмжлэг үзүүлж зөвлөгөө өглөө. Сургалт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээнд ХЭДСангаас 10,0 сая төгрөгийг зарцуулаа.<br>**Үр дүн:**<br>Хамрагдсан ААНБ-н тоо -20<br>Сургалтын тоо -2 | 100 |
| 21 | 3.2.1.3 | Аймаг, нийслэлийн хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороо, хөдөлмөрийн арбитр, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах; | | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаан тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд гарсан хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргааны тоо | Хөдөлмөрийн сонирхолын болон эрхийн маргаанаас урьдчилан сэргийлж маргааны тоог бууруулсан байна. | Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд нийт 12 иргэний 14 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч шийдвэрлэлээ. Хөдөлмөрийн эрхийн маргааны шалтгаан нөхцөлийг судалж Хөдөлмөрийн харилцааны чиглэлээр ажил олгогч, ажилтнуудыг сургалтад хамруулж, байгууллагын маргаан таслах комиссыг чадавхжуулах сургалтад 4 байгууллагын 90 албан хаагчийг хамруулж, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүллээ.<br>НУБИЭ ХХК-н 2025-2026 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний төслийн үйл ажиллагаанд үүссэн сонирхлын маргааныг зохицуулах ажиллагаанд арбитруудад дэмжлэг үзүүлж, 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж Улсын дээд шүүхээс сонирхлын маргаантай холбогдуулан хуулийг хэрэглэх явцад гарч буй хүндрэлтэй асуудлын талаар тайлбар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авч дэмжлэг үзүүллээ.<br>**Үр дүн:**<br>Сонирхлын маргааны тоо 1<br>Эрхийн маргааны тоо 14 болж өмнөх оноос 6.6 хувиар буурлаа. | |
| 22 | 3.2.1.4 | Аймаг, сумын хамтын хэлэлцээрийн байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулахад санаачлагатай ажиллах | | Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлж бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Аймгийн хэмжээнд 2024 онд бүртгэсэн хамтын хэлэлцээрийн тоо | Хамтын хэлэлцээрийг Хөдөлмөрийн хууль тоггоомжид нийцүүлж, бүртгэж. мэдээллийн сан үүсгэсэн байна. | Аймгийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт 2023-2025 оны хамтын хэлэлцээрийг байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нийт 814 хоршоо тогтмол үйл ажиллагаа явуулж, 2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөнөөс 224 хоршооны 1221 малчинд 42.2 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо. Мөн 2023-2025 онд аймгийн хэмжээнд 2170 иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, 4278 шинэ ажлын байр бий боллоо.<br>**Үр дүн:**<br>Хамтын хэлэлцээрийн тоо 1 | 100 |
| 3.2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар | | | | | | | | 97 |
| 23 | 3.2.2.1 | 2025-2028 онд орон нутгийн хөгжилд ач холбогдолтой, орон нутгийн онцлогтой үйлдвэр, үйлчилгээний салбар, чиглэлийг тодорхойлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил олгогчийн судалгааг гаргах, шаардлагатай дэмжлэгийн саналыг боловсруулах; | 1741729,0 | 1.Бодлогын баримт бичгийн тоо<br>2.Судалгаа мэдээллийн тоо | Бүсчилсэн хөгжлийн бодлого Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр | Судалгаа, шинжилгээний ажлыг хийж. шаардлагатай бодлого. үйл ажиллагааны саналыг боловсруулсан байна | Манай аймаг нь газар тариалан, мал аж ахуйн бүс нутаг бөгөөд нийслэл хотын сүүний хэрэгцээний 45 хувь, мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээний 40 хувь, төмс, хүнсний ногооны 56.5 хувийг хангадаг билээ. 2024-2028 онд Хөдөө аж ахуйн стратегийн бүс нутаг, Хүнс үйлдвэрлэгч, экспортлогч улс болох Засгийн газрын зорилтыг хангах түшиц аймаг болох, “Нийлүүлэгчийн зэрэгцээ үйлдвэрлэгч аймаг болох” урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Мөн Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, баялаг бүтээгчдийг дэмжих, аймаг орон нутгийн хөгжилд иргэд олон нийт, ААНБ-уудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Аймаг хөгжүүлэх сангийн журам"-ыг батлуулан 2017 оноос эхлэн хэрэгжүүлж 2025 оны байдлаар 290 гаруй иргэд ААНБ, хоршоодод 6.0 | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо.<br>Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 7 төрлийн судалгаа мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Үр дүн:<br>Бодлогын баримт бичгийн тоо – 3<br>Судалгаа мэдээллийн тоо - 7</td><td></td></tr>
<tr><td>24</td><td>3.2.2.2</td><td>Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, шинээр бий болох ажлын байр, ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг нарийвчлан тооцож, хэрэгцээтэй хүний нөөцийн тоо мэдээг салбар, мэргэжил бүрээр гаргах;</td><td></td><td>Судалгаа, мэдээллийн тоо</td><td>Албан есны статистик (Ажиллах хүчний судалгаа)<br>Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний мэдээллийн сан(E»ЮB систем)</td><td>Аймгийн/сум тус бүрээрх/ ажилгүйдэл, хөдөлмөр эрхлэлт, ядуурлын тоон мэдээллийн чанар сайжирч, судалгаа, бүртгэл мэдээллийн сан үүссэн байна</td><td>Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгааг 1-р улиралд зохион байгуулж 845 иргэнийг хамрууллаа. Судалгаанд ажил идэвхтэй хайж байгаа 662, санхүүгийн дэмжлэг, арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй -440, зөвлөгөө мэдээлэл авах-496, сургалтад хамрагдах хүсэлтэй 668 иргэний мэдээллийг нэгтгэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн платформ Ejob-д 240 ажил олгогч байгууллагаас 1126 ажлын байрны захиалгыг хүлээн авч 154 ажил олгогчийн 454 ажлын байрны захиалгыг хангаж ажиллаа.
<table>
<tr><th>№</th><th>Салбар</th><th>Захиалга</th><th>Зуучла</th></tr>
<tr><td>1</td><td>ХАА</td><td>146</td><td>54</td></tr>
<tr><td>2</td><td>Боловсруулах үйлдвэр</td><td>176</td><td>63</td></tr>
<tr><td>3</td><td>Худалдаа үйлчилгээ</td><td>142</td><td>51</td></tr>
<tr><td>4</td><td>Төрийн удирдлага</td><td>161</td><td>79</td></tr>
<tr><td>5</td><td>Боловсрол</td><td>171</td><td>105</td></tr>
<tr><td>6</td><td>Эрүүл мэнд</td><td>98</td><td>44</td></tr>
<tr><td>7</td><td>Бусад</td><td>311</td><td>204</td></tr>
<tr><td></td><td>ДҮН</td><td>1126</td><td>454</td></tr>
</table>
Ажил мэргэжлийн ангилалаар:
<table>
<tr><th>Ажил мэргэжил</th><th>Захиалга</th><th>Зуучла</th></tr>
<tr><td>Менежер</td><td>24</td><td>15</td></tr>
<tr><td>Мэргэжилтэн</td><td>308</td><td>161</td></tr>
<tr><td>Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн</td><td>38</td><td>11</td></tr>
<tr><td>Контор, үйлчилгээний ажилтан</td><td>34</td><td>14</td></tr>
</table></td><td>100</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| Худалдаа, үйлчилгээний ажилтан | 177 | 72 |
| Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан | 70 | 14 |
| Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил | 126 | 50 |
| Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч | 80 | 41 |
| Зэвсэгт хүчний ажил, мэргэжил | 9 | 2 |
| Энгийн ажил, мэргэжил | 260 | 74 |
| ДҮН | 1126 | 454 |

Эрэлттэй ажлын байрыг мэргэжилээр ангилвал:

| Салбар | Эрэлт | Эрэлт мэргэжлийн чиглэлээр |
|---|---|---|
| Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт | 113 | Нарийн мэргэжлийн инженер 21, ХАБ-н инженер 2, инженер техникийн ажилтанууд 20, Үйлдвэрийн шугамы ажилтан 70 |
| Хөдөө аж ахуй | 92 | Хөдөө аж ахуйн техник 16, шувуучин 12, тусла малчин 12, Газар тариалангийн ажилтан 12, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн 8, бусад 3 |
| Худалдаа үйлчилгээ | 92 | Худалдааны зөвлөх 13 Бараа өргөгч 15, худалдагч 45, Касс 12, бусад туслах ажилтан 1 |
| Барилга | 67 | Өрлөгчин 3, Цахилгаанчин 5, инжене 1, сантехникч 6, туслах ажилтан 52 |
| Боловсрол | 66 | Цэцэрлэгийн багш, туслах багш 5, эмч 4, Сургуулийн эргэжлийн багш 31, Бусад туслах ажилтан 26 |
| Эрүүл мэнд | 54 | Их эмч-24, Бага эмч - 1 Сувилагч 14 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><table><tr><td>Уул уурхай</td><td>40</td><td>Хүнд машин механизмын оператор 17, гүний уурхайн машинист 20, механикч 5</td></tr><tr><td>Бусад</td><td>148</td><td></td></tr><tr><td>НИЙТ</td><td>672</td><td></td></tr></table>Үр дүн:<br>Судалгаа, мэдээллийн тоо – 845 иргэнээс судалгаа авч, 7 төрлийн судалгаа мэдээллийн сан бүрдүүллээ.</td><td></td></tr>
<tr><td>25</td><td>3.2.2.3</td><td>Орон нутгийн хүн амын бүлгүүд /эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, оюутан залуучууд зэрэг/-ийн хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, ядуурлын нөхцөл байдлын судалгаа хийх, бүртгэл мэдээллийн сан үүсгэх, онцлог хэрэгцээнд нь нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</td><td></td><td>1 Аймгийн ажилгүйдэл. ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь<br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь<br>3 Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө. гүйцэтгэлийн өсөлтийн хувь</td><td>Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэлядуурлын үзүүлэлтийн гүйцэтгэл<br>2023 он - Ажиллах хүмний оролцооны түвшин улсын хэмжээнд 59.5%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3%, ажилгүйдлийн түвшин 5.3%<br>2022 он - ядуурлын түвшин</td><td>Хүн амын бүлэг тус бүрээрх судалгаа хийгдэж, бүртгэл мэдээллийн сан үүсч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.</td><td>Орон нутгийн хүн амын бүлгүүдээс хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаанд 25 сумын 845 иргэн хамрагдсанаас Ажилгүй 631, Ажилгүйдэлд өртөж болзошгүй 161, Ажил олоход хүндрэлтэй 53 иргэн хамрагдаж судалгаа мэдээллийн сан бүрдүүллээ. Судалгаанд хамрагдагсдын 434 нь эрэгтэй, 411 нь эмэгтэйчүүд байна. Судалгаанд хамрагдсан иргэдээс Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх чадварын үнэлгээнд 123, АМЧБОлгох ганцаарчилсан сургалтад 33, нийт 156 иргэнийг зөвлөгөө мэдээлэл авах хэрэгцээний дагуу хамруулж, 27 иргэнийг санхүүгийн дэмжлэгт, 60 иргэнийг ажилд зуучилж, нийт 87 иргэн ажлын байраар хангагдлаа.<br>Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь ХЭДСангаас олгох санхүүгийн дэмжлэгийг сумдад нээлттэй зарлахаар шийдвэрлэсний дагуу 139 төсөлд 1,303,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож 139 ажлын байр бий боллоо. Аймгийн хэмжээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 0,5 хувьтай байна.<br>Үр дүн:</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөдөө 35 6%. аймгийн төв 26.1%. сумын төв 30 6%. хөдөө нутаг 41.2% | | 1 Аймгийн ажилгүйдэл. ядуурал, хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн тооны өсөлт, бууралтын хувь – Ажилгүйдлийн түвшин 0,5 хувьд хүрч, улсын дунджаас 5 пунктээр бага зэрэг үзүүлэлттэй байна.<br>2.Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хэрэгжилтийн тооны өсөлтийн хувь – Аймгийн хэмжээнд 608 иргэнийг ажилд зуучилж 1395 шинэ ажлын байр бий боллоо.<br>3.Аймгийн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд төлөвлөсөн хөрөнгө – ХЭДсан 1,3 тэрбум | |
| 26 | 3.2.2.4 | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа авдаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэний хөдөлмөр эрхлэх, аж ахуй эрхлэх хүсэл сонирхол, санал санаачилгыг бий болгох, дэмжих замаар халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хэрэгжилтийг хангуулах | | 1 .Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо<br>2 Холбогдох арга хэмжээний тоо<br>З.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 он ДНБ-д нийгмийн тусламжийн зардлын эзлэх хувийн жин 3.7%, /2023 он/ | Аймгийн хэмжээнд халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бодитой хэрэгжиж, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн байна. | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийг хөгжүүлэх амьдрах ухааны сургалтад нийт 1457 иргэдийг хамруулж, 112 иргэнийг байнгын ажлын байранд, 8 иргэнийг төсөл хөтөлбөрт, 462 иргэнийг түр ажлын байранд зуучилж, 94,100.0 мянган төгрөгөөр өрхийн орлогыг нэмэгдүүллээ.<br>**Үр дүн:**<br>1 Нийгмийн халамж авагчаас хөдөлмөр эрхлэгч болсон иргэний тоо 112<br>2 Холбогдох арга хэмжээний тоо - хөгжүүлэх амьдрах ухааны сургалтад нийт 1457 иргэдийг хамруулаа.<br>З.Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ – 94,1 сая төгрөг | 100 |
| 27 | 3.2.2.5 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлэх; | | 1. Ажилд зуучлуулсан иргэний тооны өсөлт<br>2.Холбогдох арга хэмжээний тоо | | Аймгийн хэмжээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжин ажиллагсдын тоо нэмэгдсэн байна. | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан өдөрлөг, малчдын зөвлөгөөн, нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг 18 удаагийн арга хэмжээнд оролцож, 1030 гаруй ажил хайгч иргэн, 48 ажил олгогчдод Ижоб платформын талаар мэдээлэл хүргэлээ. ,Жоб центрийн үйл орон | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нутагт эхлүүлж, хамтран ажиллах талаар Улаанбаатар хотын Хан Уул, Баянгол дүүргүүдэд мэргэжилтнүүдийг туршлага судлуулан, хамтран ажиллах биржийн урилгыг олон нийтэд 2 удаа нээлттэй зарласан. МУШМА, Сонор, Төгс аялгуут хөдөлмөрийн биржүүд хамтран Жоб центрийг ажиллуулахаар стандартын шаардлагыг хангах байр, танхимыг судалж байна.<br>Аймгийн хэмжээнд 1395 шинэ ажлын байр бий болж, 608 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.<br>**Үр дүн:**<br>Ажилд зуучлуулсан иргэний тоо –<br>Шинэ ажлын байр 1395<br>Байнгын ажлын байр -608<br>Холбогдох арга хэмжээний тоо - 18 | |
| 28 | 3.2.2.6 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан ААНБ, ТББ, хувь хүн санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх, ажлын байр бий болгосон эсэхэд хяналт тавих; | | 1 Хяналт шалгалтын тоо<br>2.Судалгаа. мэдээллийн тоо<br>3 Холбогдох арга хэмжээний тоо | Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоо 30.9 мянга /2024 оны 4 улирал/<br>Цалин хөлстэй ажиллагч 318.9 мян хүн /2023 онУ | Аймгийн хэмжээнд цалин хөлстэй ажил эрхлэгч болон албан хөдөлмөр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна | ХЭДСангаас 2022-2025 онд 5 хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 776 иргэний мэдээллийг и-жоб системд бүртгэн 6 төрлийн мэдээллийн сан бий болгож, төслийн үйл ажиллагаанд сумдын мэргэжилтнүүд болон газрын дотоод хяналтаар 5 удаа хяналт хийлээ..<br>18 төслийн үйл ажиллагаа хаягийн шилжилт хийгдэж өөрчлөгдсөн, 4 иргэн нас барж үйл ажиллагаа нь зогссон, 23 төсөл хэрэгжүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаа өөрчлөгдсөн зэрэг зөрчил илэрсэн бөгөөд 17 иргэнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллаа.<br>Ажлын байр бий болгосон чиглэлээр 128 төсөлд хяналт хийхэд зөрчил илрээгүй.<br>Хяналтын үеэр 101 төсөл хэрэгжүүлэгчээс 82,200.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, эргэн төлөлтийг 16,9 хувиар нэмэгдүүллээ. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 онд нийт 139 төсөлд санхүүжилт олгосноос НДШ төлүүлэхээр 86 төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгууллаа.<br>**Үр дүн:**<br>1 Хяналт шалгалтын тоо -5<br>2.Судалгаа. мэдээллийн тоо -6<br>3 Холбогдох арга хэмжээний тоо -17 иргэнийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, эргэн төлөлтийг 16,9 хувиар нэмэгдүүллээ. | |
| 29 | 3.2.2.7 | Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртэй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлэх; | | Холбогдох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо<br>Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашипгай загвар/-н тоо | 2023 онд ХЭДС-аас шилдэг старт- ап залуучуудад олгох санхүүгийн дэмжлэгт 139 хүнийг хамруулж, 721.0 сая төгрөг зарцуулсан | Аймгийн хэмжээнд өндөр технологийн, бүтээмжтэй ажлын байрны тоо, аж ахуй эрхлэгч нэмэгдсэн байна | Шинэлэг санаа бүхий стартап бизнесээ эхлүүлж байгаа залуусыг тодруулах, залуучуудын идэвхийг нэмэгдүүлэх Бүсийн уралдаанд Төв аймгаас 2 баг оролцож, 1 баг Зоорийг автоматжуулах төслөөр шалгарч 20,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 3-5 шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой боллоо. Аймгийн старт апп арга хэмжээнд 7 баг оролцсоноос Хүнсний ногоог бордох эко бордоо үйлдвэрлэл, Залуучуудын бүтээлч танхим төслүүд шалгарч тус бүр 15,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч, шинээр 4 ажлын байр бий боллоо.<br>**Үр дүн:**<br>Холбогдох арга хэмжээнд хамрагдсан хүний тоо -14<br>Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ – 50,0 сая төгрөг<br>Шинээр бүртгүүлсэн патент/шинэ бүтээл, ашипгай загвар/-н тоо - 3 | 100 |
| 30 | 3.2.2.8 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж, арга барилыг сайжруулж | | 1.Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо,<br>2Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ | 2023 онд ХЭДС-аас борлуулалтын дэмжлэгт 460 хүн хамрагдаж 341,3 сая | ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн борлуулалтын дэмжлэгийн арга хэмжээ төрөлжин нэмэгдэж. хамрагдагсдын | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн үйлвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх “Борлуулалтын цэг”-ийг Аз жаргалын өргөө төв, Төв аймагт үйлдвэрлэв дэлгүүрийг түшиглэн байгуулж, хамтран ажиллах гэрээ байгууллаа. “Аз жаргалын өргөө” төв нь пэйж хуудсаараа дамжуулан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгох; | | | төгрөг зарцуулсан | тоо. борлуулалтын хэмжээ нэмэгдсэн байна | борлуулалтын захиалга авч хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулж 1,700.0, "Төв аймагт үйлдвэрлэв" дэлгүүр нь 8 сумын 32 иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулж 3,600.0, нийт 39 иргэний 5,300.0 мянган төгрөгийн борлуулалтыг хийлээ. ХЭДСангаас борлуулалтын цэгт нийт 4,800.0 мянган төгрөгийн урсгал зардлыг олгов.<br>Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 25 сумын 61 иргэн "Цагаан сар-2025", "Алтан намар-2025" арга хэмжээнд 18 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 49,400.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, өрхийн орлогоо нэмэгдүүллээ.<br>Борлуулалтын цэг, үзэсгэлэн худалдаагаар нийт давхардсан тоогоор 100 иргэний 18 нэр төрлийн бүтээгдэхүүнийг борлуулж 54,700.0 мянган төгрөгийн борлуулалт хийлээ.<br>**Үр дүн:**<br>Борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүний тоо – 100 иргэний 18 нэр төрлийн бүтээгдэхүүн<br>Төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хэмжээ - ХЭДСангаас борлуулалтын цэгт нийт 4,8 сая төгрөг олгов. | |
| 31 | 3.2.2.9 | Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах | | Холбогдох арга хэмжээний тоо | 2023 онд ХЭДС-аас хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллага | Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн үйл ажиллагаа өргөжиж. нийгмийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ нэмэгдсэн байна | ХЭАЗөвлөлийн шинэчлэн байгуулж, 2025 оны анхны хуралдаанаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг аймгийн хэмжээнд нээлттэй зарлахаар шийдвэрлэлээ. Зөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор ХЭДСангийн зарцуулалтыг хянах, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд нийгмийн түншлэгч талуудын оролцоог ханган ажиллалаа.<br>Мөн аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамран 200 гаруй албан хаагчдад "Хөдөлмөрийн харилцаанд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аг дэмжихэд 160.7 сая төгрөг зарцуулсан. | | анхаарах асуудлууд" "Хөдөлмөрлөх эрх" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Аймгийн ҮЭ-ийн Холбоо "Залуучуудын зохистой хөдөлмөр" үндэсний сүлжээтэй хамтран "ЗАЛУУЧУУДЫН ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР" сэдэвт сургалтыг нийгмийн түншлэгч байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, сургалтад нийт 35 байгууллагын 40 албан хаагч хамрагдлаа.<br>Зөвлөлийн гишүүдийг ХЭДСангийн зарцуулалтыг хянах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг сурталчлах, төсөл сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд оролцуулж, 1,200.0 мянган төгрөгийн урамшууллыг ХЭДСангаас олголоо.<br>**Үр дүн:**<br>Холбогдох арга хэмжээний тоо- 5 | |
| 32 | 3.2.2.10 | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3, 145.4 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулах. | | 1.Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ<br>2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ<br>3.Бий болсон ажлын байр, ажилд зуучлагдсан хүний тоо | 2023 онд ХЭДС-нд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрөөс 6.9 тэрбум төгрөгийн орлого | Аймгийн хэмжээнд орлого төвлөрүүлэлт нэмэгдэж. хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалтыг хангуулахаар 20 ААНэгжээс 69 иргэний 579,100.0 мянган төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлж өмнөх оноос 229,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүллээ.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэний санхүүгийн дэмжлэгт 11 сумын 21 иргэнд 200,000.0 мянган төгрөгийн, Зуунмод сумын 1 ХБИргэнд 1,200.0 мянган төгрөгийн түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийн олгож нийт 51 ажлын байрыг ХЗЗ-н мэдээллийн санд бүртгэсэн. 5 сумын 5 байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй 14 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.<br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхлэгч 30 ахмадад 287,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, Хүүхэд хамгаалагч арга хэмжээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төвлөрсөн. | | цагдаагийн байгууллагын 2, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 25 байгууллагад 31 ахмад нийт 33 ахмадыг түр ажлын байранд ажиллуулж 33,5 сая төгрөгийн урамшууллыг ХЭДСангаас олгож, 14 сумын 19 байгууллагад 27 ахмадыг ажилд зуучиллаа.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р зүйлийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 50 аж ахуй нэгж байгууллага хамрагдсанаас хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулаагүй 10 аж ахуйн нэгж байгууллагад 175968.5 мянган төгрөгийн нөхөн төлбөр, 15000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулснаас 9 аж ахуйн нэгж байгууллагын 174384,5 мянган төгрөгийг ХЭДСанд төвлөрүүлж, 13500.0 мянган төгрөгийн торгуулийг төлүүллээ. Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалтын дагуу Борнуур суманд Уул уурхай чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Гүнбилэг гоулд ХХК нь 63360,0 мянган төгрөгийн нөхөн төлбөр төлүүлэх акт тогтоолоо.<br>Хөгжлийн бэрхшээлтэй болон Ахмад нийт 125 иргэн ажлын байртай боллоо.<br>**Үр дүн:**<br>Төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ – 766,9 сая төгрөгийг ХЭДСанд төвлөрүүллээ.<br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн хэмжээ – 320.5 сая төгрөг.<br>Бий болсон ажлын байр, ажилд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зуучлагдсан хүний тоо - 125 | |
| 3.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар | | | | | | | | 90 |
| 33 | 3.2.3.1 | Орон нутгийн түвшинд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааныг судалж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөн, зарцуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн захиргааны хяналтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | ХАБЭА-н тухай хуулинд заасан шаардлагыг хангасан эсэх | 2024 оны хэрэгжилт | Хуульд заасан хэмжээнд хүргэсэн байна | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил: Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт уриан дор сарын аяныг зохион байгуулж, сумдын ХАБЭА-н салбар зөвлөл, Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулллаа. Мөн ХАБЭМэндийн төвтэй хамтран ААНБ-ын ХАБЭА-н ажилтан, ХХЭрхлэгчдийг үйлдвэрлэлийн осол, аюултай хортой, хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 132 ААНБ-ын 554 албан хаагчийг хамруулж сертификат олголоо. Хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөгийг зарцуулллаа. Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар үйлдвэрлэлийн ослын 29 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 2-оор тохиолдлоор буурлаа.<br>**Үр дүн:**<br>Сургалт нөлөөллийн арга хэмжээнд 132 ААНБ-ын 554 албан хаагчийг хамруулллаа.<br>Үйлдвэрлэлийн ослын 29 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 2-оор тохиолдлоор буурлаа.<br>Хөдөлмөрийн хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 12.6 сая | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийг зарцуууллаа. | |
| 34 | 3.2.3.2 | Аймаг, дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хувиараа, албан бус хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчдыг үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1 Төлөвлөсөн төсөв 2. Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2024 оны гүйцэтгэл | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн сургагч багш, эрсдэлийн үнэлгээний мэргэшсэн зөвлөх, ХАБЭА-н хяналтын аудитор багш нартай хамтран ХАБЭА-н Зөвлөлийн гишүүд, ҮОХХСудлан бүртгэх комиссын нийт 260 гаруй гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулж, сертификат олголоо. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөгжил: Хиймэл оюун ухааны хэрэглээ ба цахимжилт уриан дор сарын аяныг зохион байгуулж, сумдын ХАБЭА-н салбар зөвлөл, Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрууллаа. Мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээнд 463 байгууллага, 10257 ажилтан, албан хаагч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамрууллаа.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 84,3 хувьтай, ХАБАЭ-н салбар зөвлөлийн төлөвлөгөөг 85 хувьтай хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн төсвөөс нийт 14,9 сая төгрөгийг зарцууллаа.<br>**Үр дүн:**<br>Төлөвлөсөн төсөв – 14,9 сая төгрөг. Зохион байгуулсан арга хэмжээний тоо- 3 | 84,3 |
| 35 | 3.2.3.3 | Хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулсан үйлдвэрлэлийн томоохон осол, хурц | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1 Төлөвлөсөн төсөв<br>2Тухай бүр авсан арга | 2024 оны гүйцэтгэл | Тухай бүр арга хэмжээ авсан байх | Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар үйлдвэрлэлийн ослын, 29 тохиолдол бүртгэгдэж 32 ажилтан өртсөнөөс хүйсийн харьцаагаар авч үзвэл эрэгтэй 25 ажилтан буюу 78,1%, | 30 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хордлогын үед түүний хор уршгийг арилгах, хүн амыг авран хамгаалахад чиглэгдсэн шуурхай арга хэмжээг авах. | | хэмжээний тоо | | | эмэгтэй 7 ажилтан буюу 21,9%-ийг эзэлж байна. Үүнээс амь насаа алдсан 6, гэмтсэн 26 тохиолдол бүртгэгдлээ. Үйлдвэрлэлийн ослыг гарсан орчин нөхцөлөөр нь үзвэл ажлын байр буюу үйл ажиллагааны дотор орчинд 26, үйл ажиллагааны талбайн гадна орчинд 3 байна. Ослыг салбараар авч үзвэл Уул уурхайн олборлолтын салбарт 6, боловсруулах үйлдвэр 5, барилга 3, худалдаа үйлчилгээний салбарт 3, боловсролын салбарт 3 тус тус бүртгэгдсэн байна.<br>**Үр дүн:**<br>Төлөвлөсөн төсөв – ОНТ - 1,3 сая төгрөг<br>Тухай бүр авсан арга хэмжээний тоо – Үйлдвэрлэлийн ослын 32 актыг хянан баталгаажуулав. | |
| 3.2.4 Ажиллах хүчний шилжилт, хөдөлгөөний талаар | | | | | | | | 100 |
| 36 | 3.2.4.1 | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих; | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр | 1 Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо<br>2. Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн орлогын хэмжээ<br>3. Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, гадаад | 2024.12.15 байдлаар: Орон нутагт хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо 8.1 мянган хүн | Аймгийн хэмжээнд ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авсан ААНБайгууллагуудтай Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах уулзалтыг зохион байгууллаа. Хөдөлмөрийн зах зээлийн ижоб программд 15 сумand 31 байгууллагаас 1078 гадаад ажилтныг авч ажиллуулах захиалга ирүүлснээс 825 ажилтан ажиллаж байна. Нарийн мэргэжилтэн шаардлагатай 7 байгууллагын 18 ажлын байранд 45 монгол хүн дагалдан ажиллаж байна.<br>**Үр дүн:**<br>Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж байгаа гадаад ажилтны тоо - 825<br>Нарийн мэргэжилтэн шаардлагатай 18 ажлын байранд 45 монгол хүн дагалдан ажиллаж байна. | 100 |
| 37 | 3.2.4.2 | Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид | Орон нутгийн төсвийн | | | Хуулийн хэрэгжилт сайжирсан байна. | Аймгийн хэмжээнд 17 сумын 53 аж ахуйн нэгж байгууллагад 1937 гадаад ажилтан оруулж ирснээс БНХАУ-ын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах. | хөрөнгөөр | ажилтны тоо хэмжээний харьцааны өөрчлөлт | | | 1932 иргэн, БНСУ-ын 1 иргэн, Энэтхэг улсын 2 иргэн, Япон улсын 2 иргэн ажиллуулахаар зөвшөөрөл авч төлбөрийг ХХҮЕГазарт төвлөрүүллээ. Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 7 объект хамрагдаж 434 ажилтан ажиллаж байгаагаас монгол 237, гадаад 197 ажилтан, монгол ажилтны эзлэх хувь 54,6 байна. Борнуур суманд Уул уурхай чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Гүнбилэг гоулд ХХК нь Ашигт малтмалын тухай хуулийн 43-р зүйлийн хэрэгжилтийг хангаагүй тул 63,360,0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг орон нутгийн санд төлүүлэх акт тогтоолоо.<br>**Үр дүн:**<br>Гадаад ажилтан ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын монгол, ажилтны эзлэх хувь – 54.6% | |
| 3.3 Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн туай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Ахмад настны тухай хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллана. | | | | | | | | |
| 3.3.1 Нийгмийн даатгалын талаар | | | | | | | | 90 |
| 38 | 3.3.1.1 | Орон нутгийн иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, залуучуудыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах; | 2.179.420.3 | Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь | Улсын хэмжээнд сайн дураар даатгуулагчийн тоо 2023 он 152800 | Сайн дураар даатгуулагчийн тоог 10-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын багц хууль, нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд 321 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээнд 230 ажил олгогч, 23150 иргэд, даатгуулагчдыг хамрууллаа. Үүний үр дүнд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 5940 иргэнийг хамруулж, өмнөх оны мөн үеэс 440 даатгуулагч буюу 8 хувиар өссөн дүнтэй байна.<br>**Үр дүн:**<br>Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчийн тооны өсөлтийн хувь-Сайн дурын даатгалд 5940 иргэнийг хамруулж, өмнөх оны мөн үеэс 440 | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даатгуулагч буюу 8 хувиар өссөн дүнтэй байна. | |
| 39 | 3.3.1.2 | Нийгмийн даатгалын үйлчилгээг аймаг, дүүргийн иргэдэд шуурхай хүргэх зорилгоор нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | | | | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 100% цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | Нийгмийн даатгалын салбарт 2024 оноос мэдээллийн системийн шинэчлэл хийгдэж нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажил үе шаттай хийгдэж байна. Энэ хүрээнд аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 17314 тэтгэврийн хувийн хэргийг 100 хувь цахимжуулж, мэдээллийн санг үүсгэн ажиллалаа.<br>**Үр дүн:**<br>17314 тэтгэврийн хувийн хэргийг 100 хувь цахимжууллаа. | 100 |
| 40 | 3.3.1.3 | Даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах хүрээнд ажил олгогч хуулиар хүлээсэн эрх, үүргээ биелүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байх, өр үүссэн тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг шуурхай барагдуулахад Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх; | | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо | Улсын хэмжээнд өртэй төсөвт байгууллагын тоо-848, өр, авлагагүй байна. | | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны орлогын төлөвлөгөө 61.7 тэрбум төгрөг оруулахаас 63.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 103.5 хувиар давуулан биелүүллээ. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил” ,“ Итгэлцлийн аяныг зохион байгуулж 2025 оны шимтгэлийн авлагын эхний үлдэгдэл 2.1 тэрбум төгрөг байсныг 2025 оны жилийн эцсийн байдлаар 0.6 тэрбум төгрөгт хүргэж, оны эхнээс 302 аж ахуйн нэгж, байгууллагын 1.5 тэрбум төгрөгөөр буюу 71.4 хувиар бууруулж ажиллалаа.<br>**Үр дүн:**<br>НДШ-н хуримтлагдсан авлага 2.1 тэрбум төгрөг байсныг 2025 оны жилийн эцсийн байдлаа 0,6 тэрбум төгрөгт хүргэж, оны эхнээс 302 аж ахуйн нэгж, байгууллагын 1,5 тэрбум | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгөөр буюу 71,4 хувиар буурууллаа.<br>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын тоо -0 | |
| 41 | 3.3.1.4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчлүүлэх нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах; | | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо | Улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 102446 | Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоог 25 хувиар бууруулсан байна. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь 2025 онд 42 удаа 243 цаг хуралдаж 1796 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцсэн бөгөөд үүнээс 326 хүний ХЧА-ыг шинээр тогтоож, 1198 хүний ХЧА-ын хугацааг сунгаж, 201 иргэнийг ХЧА-ыг цуцалж, 71 хүнийг шинжилгээ дутуу үндэслэлээр буцааж шийдвэрлэсэн байна. Дээрх хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоолгосон иргэдээс хувь өссөн 36, хувь буурсан 37, хөдөлмөрийн нөхцөл сольсон 2 хүн байна.<br>**Үр дүн:** 201 иргэний ХЧА-ыг цуцалж, 2024 оноос 7,3 хувиар буурлаа. | 100 |
| 42 | 3.3.1.5 | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаа хийхэд хамтран ажиллах; | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | | Хуримтлалын сангийн үйл ажиллагаатай холбогдуулан орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох тооцоо судалгаатай болсон байна. | Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг бий болгож, ажил олгогч, даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлээс тус бүр 2 хувиар суутган тэтгэврийн нөөц санг бүрдүүлж байна.<br>**Үр дүн:**<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо- тэтгэврийн даатгалын шимтгэлээс тус бүр 2 хувиар суутган тэтгэврийн нөөц санг бүрдүүлж байна. | 100 |
| 3.3.2 Нийгмийн халамжийн талаар | | | | | | | | 90 |
| 43 | 3.3.2.1 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, | Орон нутгийн төстийн хөрөнгөөр | Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо. үүнээс хүнсний | - | Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтыг зохион байгуулж, “Монголын Удирдлага шинэчлэлийн академи” НҮТББ шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд согтууруулах мансууруулах бодис хэрэглэдэг өрхийг хамруулах | | эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхөөс шинээр хөдөлмөр эрхэлсэн иргэний тоо | | иргэдийг орлогын эх үүсвэртэй болгох, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд хамруулсан байна | ОНОТХҮйлчилгээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг Зуунмод сумын 40 өрх, Батсүмбэр сумын 11 өрхийн 128 иргэнийг сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамруулж, 5 бүлэгт 9,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, 22 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.<br>**Үр дүн:**<br>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 29,9 сая төгрөг батлав.<br>Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо-128<br>Хөдөлмөр эрхэлсэн хүний тоо-27 | |
